ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

## Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/4/СТА-ТШ3

---

Цахим хуудас: www.audit.mn
Дорноговь аймаг , Сайншанд сум
2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 99092469 Цахим хаяг: ..............................
Аудитын менежер: Э.Энхцэцэг
Утас: 90077079 Цахим хаяг: ..............................
Аудитор: Г.Энхтөр
Утас: 96441690 Цахим хаяг: ..............................

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.
Дорноговь аймгийн Төрийн аудитын газар , Сайншанд сум , Орон нутгийн өмчийн 3 дугаар байр

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга

1 Аудитын гэрчилгээ 3
2 Аудитын тайлан 5
2.1 Оршил........5
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага........5
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт........6
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин........6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ........7
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал........7
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар........8
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн........8
2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал…..9
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал........9
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга........10
2.11. Шилэн дансны мэдээлэл........10
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга........10
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл........10
3 Менежментийн захидал 11
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан 12

# 1 Аудитын гэрчилгээ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.02.26 № 1-6/207

танай________________-ны №________________-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАМЫН-ҮҮД СУМЫН ХҮҮХДИЙН
5 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
П.БҮРЭНТЭГШ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг цэцэрлэгийн эрхлэгч П.Бүрэнтэгшид танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар 19-нөөс 2019 оны 2 дугаар сарын 19–ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэг нь СӨБ-ын үйлчилгээний шинэ арга хэлбэрийг дэмжих замаар хүүхэд бүрийг зохион байгуулалттай сургалт , хөгжүүлэх үйл ажиллагаанд тогтмол хамруулж , бага насны хүүхдийг хөгжүүлэх ажлын чанарыг сайжруулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургуулийн өмнөх насныханд анхан шатны боловсрол олгох үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд томоохон шинэчлэлт , өөрчлөлт гараагүй

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого холбогдох дүрэм , журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй  гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэг санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт задлын хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу зардлыг санхүүжүүлж байгаа тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс материаллаг байдлын түвшинг тогтоосонтой холбоотой юм.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2018 оны нийт зардал 199,894.9 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 399.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь нэг удаагийн ажил гүйлгээний дүнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 1 | 64,151.70 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 2 | 6,952.00 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 0 | 0.00 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| | Дүн | 3 | 71,103.70 | |

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### 2.8.1.1 Балансын данстай холбоотой асуудал

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 6930968,51 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй бөгөөд үүнээс НДШ-ийн илүү төлсөн авлага 3235991,63 төгрөг байна
Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:
Төлбөрийн акт тогтоох

#### 2.8.1.2 Зардлын данстай холбоотой асуудал

Ээлжийн ажилчид буюу манаач нарын ээлжийн графикийг сарын эхэнд баталж мөрддөггүй , 1 дүгээр сард Ч.Гүнжаламд ажил хавсарсны нэмэгдлийг 2 хоногоор илүү тооцож 21011,5 төгрөг илүү олгосон байна
Энэ нь үнэн зөв байх , эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Байгууллагын дотоод журам , Хөдөлмөрийн тухай хууль тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн:
Төлбөрийн акт тогтоох

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй

### 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 200,935.4 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 186,278.9 мянган төгрөг буюу 92.7 хувьтай байгаа нь цалин хөлс , нэмэгдэл урамшууллын зардал хэмнэгдсэнээс шалтгаалжээ.

### 2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар буюу өмнөх аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

# 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. 2018 оны жилийн эцэст үндсэн хөрөнгийн тооллого хийсэн гэх боловч эд хариуцагч нарт эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл /НХМаягт БМ-10/-г хөтлөөгүй байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

**3.1 Балансын данстай холбоотой асуудал**

3.1.1 Илрүүлэлт:

2018 оны жилийн эцэст үндсэн хөрөнгийн тооллого хийсэн гэх боловч эд хариуцагч нарт эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл /НХМаягт БМ-10/-г хөтлөөгүй байна.

Энэ нь иж бүрэн байдал , эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан заавар тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Ажилтан албан хаагчдын ашиглаж байгаа үндсэн хөрөнгийг эд хариуцагчийн карт хөтлөөгүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан зааврын дагуу эд хариуцагч бүрт эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл /НХМаягт БМ-10/ -ийг бүрэн хөтлөх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

# 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Төгрөгөөр

| | Үзүүлэлт | ҮЛДЭГДЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 19,856,167.00 | 27,965,851.81 |
| 27 | АВЛАГА | 7,909,252.00 | 6,930,968.51 |
| 28 | Ажиллагсадтай холбогдсон авлага | - | 6,873,825.61 |
| 34 | Бусад авлага | 7,909,252.00 | 57,142.90 |
| 35 | Байгууллагаас авах авлага | 7,909,252.00 | 57,142.90 |
| 60 | БАРАА МАТЕРИАЛ | 11,946,915.00 | 21,034,883.30 |
| 61 | Түүхий эд материал | - | 4,048,038.00 |
| 62 | Тусгай зориулалттай материал | - | 4,004,838.00 |
| 63 | Эм боох материал | - | 43,200.00 |
| 66 | Хангамжийн материал | 11,946,915.00 | 16,986,845.30 |
| 67 | Бичиг хэргийн материал | 1,074,400.00 | 1,119,400.00 |
| 68 | Аж ахуйн материал | 10,294,881.50 | 12,896,771.50 |
| 70 | Түлш шатах тослох материал | - | 673.80 |
| 72 | Хүнсний материал | 542,959.50 | 2,957,000.00 |
| 73 | Бусад хангамжийн материал | 34,674.00 | 13,000.00 |
| 86 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 21,436,766.82 | 64,151,725.52 |
| 106 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 21,436,766.82 | 64,151,725.52 |
| 108 | Биет хөрөнгө | 21,216,766.82 | 26,142,725.50 |
| 113 | Машин, тоног төхөөрөмж | 16,355,770.00 | 21,626,970.00 |
| 114 | Хуримтлагдсан элэгдэл | (354,676.94) | (1,064,030.82) |
| 115 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 5,304,075.00 | 6,198,595.00 |
| 116 | Хуримтлагдсан элэгдэл | (88,401.24) | (618,808.68) |
| 126 | Биет бус хөрөнгө | 220,000.00 | 38,009,000.02 |
| 127 | Програм хангамж | - | 220,000.00 |
| 128 | Хасагдуулга | - | (21,999.96) |
| 129 | Бусад биет бус хөрөнгө | 220,000.00 | 37,800,000.00 |
| 130 | Хасагдуулга | - | 10,999.98 |
| 137 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 41,292,933.82 | 92,117,577.33 |
| 138 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 27,861.00 | 3,334.61 |
| 139 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 27,861.00 | 3,334.61 |
| 164 | Өглөг | 27,861.00 | 3,334.61 |
| 165 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 27,861.00 | 3,334.21 |
| 166 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 0.40 |
| 214 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 41,265,072.82 | 92,114,242.72 |
| 215 | Засгийн газрын хувь оролцоо | 41,265,072.82 | 92,114,242.72 |
| 216 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | - | 37,800,000.00 |
| 217 | Өмч: -Төрийн өмч | - | 37,800,000.00 |
| 223 | Хуримтлагдсан үр дүн | 41,265,072.82 | 54,314,242.72 |
| 224 | Өмнөх үеийн үр дүн | 41,265,072.82 | 41,265,072.82 |
| 225 | Тайлант үеийн үр дүн | - | 13,049,169.90 |
| 231 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 41,292,933.82 | 92,117,577.33 |

4417144353
ЕЮА0056 9025707

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

| | ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 76,376,800.50 | 212,944,118.00 |
| 76 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 25,093,027.50 | 2,262,520.00 |
| 77 | Нийтлэг татварын бус орлого | 25,093,027.50 | 2,262,520.00 |
| 81 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 25,093,027.50 | 2,262,520.00 |
| 86 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 25,093,027.50 | 2,262,520.00 |
| 111 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 51,283,773.00 | 210,681,598.00 |
| 112 | Улсын төвлөрсөн төсвөөс | 51,283,773.00 | 200,935,400.00 |
| 113 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 51,283,773.00 | 200,935,400.00 |
| 122 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 9,746,198.00 |
| 126 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны тө | - | 9,746,198.00 |
| 147 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 35,111,727.68 | 199,894,948.10 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 35,111,727.68 | 199,894,948.10 |
| 149 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 29,092,591.98 | 185,238,454.10 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 16,573,367.00 | 119,230,550.00 |
| 151 | Цалин | 13,549,900.00 | 119,230,550.00 |
| 152 | Нэмэгдэл цалин | 2,207,000.00 | - |
| 154 | Урамшуулал | 816,467.00 | - |
| 157 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 2,179,994.00 | 14,558,697.60 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 1,412,135.00 | 10,002,387.52 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 201,734.00 | 1,036,710.52 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 161,387.00 | 1,100,963.52 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 36,794.00 | 227,467.54 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 367,944.00 | 2,191,168.50 |
| 164 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 4,240,748.00 | 24,264,252.00 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 3,084,813.00 | 12,238,696.00 |
| 166 | Түлш, халаалтын зардал | - | 3,634,164.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 1,155,935.00 | 8,391,392.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 1,715,000.00 | 1,869,430.60 |
| 171 | Бичиг хэргийн материал | 515,000.00 | 425,020.00 |
| 172 | Тээвэр, шатахууны зардал | 1,200,000.00 | 399,326.60 |
| 173 | Шуудан холбоо интернетийн төлбөр | - | 175,000.00 |
| 174 | Ном, хэвлэлийн зардал | - | 53,360.00 |
| 175 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | - | 280,500.00 |
| 176 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | - | 536,224.00 |
| 181 | Нормативт зардал | 3,830,404.80 | 23,029,762.60 |
| 182 | Эм | - | 37,700.00 |
| 183 | Хоол | 3,830,404.80 | 22,992,062.60 |
| 190 | Томилолт, зочны зардал | 110,000.00 | 182,000.00 |
| 192 | Дотоод томилолтын зардал | 110,000.00 | 182,000.00 |
| 209 | Бараа үйлчилгээний бусад зардал | 443,078.18 | 2,103,761.30 |
| 211 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | - | 853,000.00 |
| 212 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 443,078.18 | 1,250,761.30 |
| 224 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 6,019,135.70 | 14,656,494.00 |
| 228 | Бусад урсгал шилжүүлэг | 3,593,400.00 | - |
| 236 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 3,593,400.00 | - |
| 237 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,425,735.70 | 14,656,494.00 |
| 240 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,425,735.70 | 14,656,494.00 |
| 268 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 41,265,072.82 | 13,049,169.90 |
| 288 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 41,265,072.82 | 13,049,169.90 |

441714435
ЕЮА0056 902576

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Төгрөгөөр

| | ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 51,283,773.00 | 210,681,598.00 |
| 110 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 51,283,773.00 | 210,681,598.00 |
| 111 | Улсын төвлөрсөн төсвөөс | 51,283,773.00 | 200,935,400.00 |
| 112 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 51,283,773.00 | 200,935,400.00 |
| 121 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 9,746,198.00 |
| 125 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | - | 9,746,198.00 |
| 147 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 51,063,773.00 | 206,588,398.00 |
| 148 | УРСГАЛ ЗАРДАЛ | 51,063,773.00 | 206,588,398.00 |
| 149 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 45,038,037.30 | 190,851,904.00 |
| 150 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 16,863,900.00 | 125,560,600.00 |
| 151 | Үндсэн цалин | 13,549,900.00 | 122,246,600.00 |
| 152 | Нэмэгдэл | 2,207,000.00 | 2,207,000.00 |
| 154 | Үр дүнгийн урамшуулал | 1,107,000.00 | 1,107,000.00 |
| 157 | Ажил олгочоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,855,000.00 | 14,047,000.00 |
| 158 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 1,180,455.00 | 10,366,200.00 |
| 159 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 168,636.00 | 920,200.00 |
| 160 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 134,909.00 | 736,200.00 |
| 161 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 33,727.00 | 184,000.00 |
| 162 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 337,273.00 | 1,840,400.00 |
| 164 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 12,150,000.00 | 16,355,000.00 |
| 165 | Гэрэл цахилгааны зардал | 6,300,000.00 | 7,040,000.00 |
| 166 | Түлш, халаалтын зардал | - | 5,075,065.00 |
| 167 | Цэвэр, бохир усны зардал | 5,850,000.00 | 4,239,935.00 |
| 170 | Хангамж, бараа материалын зардал | 9,055,773.00 | 7,614,598.00 |
| 171 | Бичиг хэрэг | 959,400.00 | 366,220.00 |
| 172 | Тээвэр, шатахуун | 1,200,000.00 | 400,000.00 |
| 173 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 175,000.00 |
| 174 | Ном, хэвлэл | - | 176,360.00 |
| 175 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 280,500.00 |
| 176 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,896,373.00 | 6,216,518.00 |
| 181 | Нормативт зардал | 4,373,364.30 | 26,044,146.00 |
| 182 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 80,900.00 |
| 183 | Хоол, хүнс | 4,373,364.30 | 25,463,246.00 |
| 184 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 500,000.00 |
| 185 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 102,560.00 |
| 186 | Багаж техник хэрэгсэл | - | 102,560.00 |
| 190 | Томилолт, зочны зардал | 110,000.00 | 182,000.00 |
| 192 | Дотоод албан томилолт | 110,000.00 | 182,000.00 |
| 208 | Бараа үйлчилгээний бусад зардал | 630,000.00 | 946,000.00 |
| 210 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 630,000.00 | 946,000.00 |
| 221 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 6,025,735.70 | 15,736,494.00 |
| 225 | Бусад урсгал шилжүүлэг | 3,600,000.00 | 1,080,000.00 |
| 233 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 3,600,000.00 | 1,080,000.00 |
| 234 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,425,735.70 | 14,656,494.00 |
| 237 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,425,735.70 | 14,656,494.00 |
| 250 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 220,000.00 | 4,093,200.00 |
| 251 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 261 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 220,000.00 | 4,093,200.00 |
| 262 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 220,000.00 | 4,093,200.00 |
| 263 | Дотоод эх үүсвэрээр | 220,000.00 | 4,093,200.00 |
| 275 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 220,000.00 | 4,093,200.00 |
| 278 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (220,000.00) | (4,093,200.00) |
| 279 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 303 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 304 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 305 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

4417144353
ЕЮА0056 9025707

## АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | | |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | | |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | 41,265,072.82 | 41,265,072.82 |
| **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | 41,265,072.82 | 79,065,072.82 |
| **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | 41,265,072.82 | 79,065,072.82 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | 41,265,072.82 | 41,265,072.82 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | | | | |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| Тайлант үеийн үр дүн | 37,800,000.00 | | 13,049,169.90 | 50,849,169.90 |
| **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 37,800,000.00 | | 54,314,242.72 | 92,114,242.72 |

4417144353
ЕЮА0056 9025707

## АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

| | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 200,935,400.00 | 186,278,906.00 | 14,656,494.00 | 92.71 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 200,935,400.00 | 186,278,906.00 | 14,656,494.00 | 92.71 |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 200,935,400.00 | 185,198,906.00 | 15,736,494.00 | 92.17 |
| 5 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 141,234,600.00 | 125,560,600.00 | 15,674,000.00 | 88.90 |
| 6 | Үндсэн цалин | 137,920,600.00 | 122,246,600.00 | 15,674,000.00 | 88.64 |
| 7 | Нэмэгдэл | 2,207,000.00 | 2,207,000.00 | - | 100.00 |
| 9 | Урамшуулал | 1,107,000.00 | 1,107,000.00 | - | 100.00 |
| 11 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 14,046,900.00 | 14,047,000.00 | (100.00) | 100.00 |
| 12 | Тэтгэврийн даатгал | 10,366,100.00 | 10,366,200.00 | (100.00) | 100.00 |
| 13 | Тэтгэмжийн даатгал | 920,200.00 | 920,200.00 | - | 100.00 |
| 14 | ҮОМШӨ ний даатгал | 736,200.00 | 736,200.00 | - | 100.00 |
| 15 | Ажилгүйдлийн даатгал | 184,000.00 | 184,000.00 | - | 100.00 |
| 16 | Эрүүл мэндийн даатгал | 1,840,400.00 | 1,840,400.00 | - | 100.00 |
| 17 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 16,355,000.00 | 16,355,000.00 | - | 100.00 |
| 18 | Гэрэл цахилгаан | 6,968,900.00 | 7,040,000.00 | (71,100.00) | 101.02 |
| 19 | Түлш, халаалт | 5,145,300.00 | 5,075,065.00 | 70,235.00 | 98.63 |
| 20 | Цэвэр, бохир ус | 4,240,800.00 | 4,239,935.00 | 865.00 | 99.98 |
| 22 | Хангамж, бараа материалын зардал | 2,096,800.00 | 2,064,160.00 | 32,640.00 | 98.44 |
| 23 | Бичиг хэрэг | 150,000.00 | 366,220.00 | (216,220.00) | 244.15 |
| 24 | Тээвэр (шатахуун) | 400,000.00 | 400,000.00 | - | 100.00 |
| 25 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 427,000.00 | 175,000.00 | 252,000.00 | 40.98 |
| 26 | Ном, хэвлэл | 139,300.00 | 176,360.00 | (37,060.00) | 126.60 |
| 27 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутг | 280,500.00 | 280,500.00 | - | 100.00 |
| 28 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 700,000.00 | 666,080.00 | 33,920.00 | 95.15 |
| 30 | Норматив зардал | 26,062,100.00 | 26,044,146.00 | 17,954.00 | 99.93 |
| 31 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 98,800.00 | 80,900.00 | 17,900.00 | 81.88 |
| 32 | Хоол, хүнс | 25,463,300.00 | 25,463,246.00 | 54.00 | 100.00 |
| 33 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 500,000.00 | 500,000.00 | - | 100.00 |
| 39 | Томилолт, зочны зардал | 190,000.00 | 182,000.00 | 8,000.00 | 95.79 |
| 41 | Дотоод албан томилолт | 190,000.00 | 182,000.00 | 8,000.00 | 95.79 |
| 53 | Бараа үйлчилгээний бусад зардал | 950,000.00 | 946,000.00 | 4,000.00 | 99.58 |
| 55 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 950,000.00 | 946,000.00 | 4,000.00 | 99.58 |
| 66 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 1,080,000.00 | (1,080,000.00) | - |
| 70 | Бусад урсгал шилжүүлэг | - | 1,080,000.00 | (1,080,000.00) | - |
| 78 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | - | 1,080,000.00 | (1,080,000.00) | - |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 200,935,400.00 | 200,935,400.00 | - | 100.00 |
| 98 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 200,935,400.00 | 200,935,400.00 | - | 100.00 |
| 99 | Улсын төсвөөс санхүүжих | 200,935,400.00 | 200,935,400.00 | - | 100.00 |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | - |
| 129 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 130 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | - |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 12 | 12 | - | 100.00 |
| 134 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.00 |
| 135 | Гүйцэтгэх ажилтан | 5 | 5 | - | 100.00 |
| 136 | Үйлчлэх ажилтан | 6 | 6 | - | 100.00 |
| 138 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | - | - | - | - |
| 148 | ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО | - | - | - | - |

4417144353
ЕЮА0856 9025707

## АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

| | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 9,746,198.00 | 9,746,198.00 | - | 100.00 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 9,746,198.00 | 9,746,198.00 | - | 100.00 |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 9,746,198.00 | 9,746,198.00 | - | 100.00 |
| 22 | Хангамж, бараа материалын зардал | 5,870,338.00 | 5,870,338.00 | - | 100.00 |
| 28 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 5,870,338.00 | 5,870,338.00 | - | 100.00 |
| 34 | Эд хогшил худалдан авах | 3,875,860.00 | 3,875,860.00 | - | 100.00 |
| 35 | Багаж, техник, хэрэгсэл | 3,875,860.00 | 3,875,860.00 | - | 100.00 |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 9,746,198.00 | 9,746,198.00 | - | 100.00 |
| 120 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 9,746,198.00 | 9,746,198.00 | - | 100.00 |
| 124 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захира | 9,746,198.00 | 9,746,198.00 | - | 100.00 |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | - |
| 129 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 130 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | - |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 12 | 12 | - | 100.00 |
| 134 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.00 |
| 135 | Гүйцэтгэх ажилтан | 5 | 5 | - | 100.00 |
| 136 | Үйлчлэх ажилтан | 6 | 6 | - | 100.00 |
| 138 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дундажаар/ | - | - | - | - |
| 148 | ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО | - | - | - | - |

4417144353
ЕЮА0056 9825707